



Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн сургалтын орчинд нөлөөлж буй хувь нэмэр, зарим үр дүн

Очирын Ирвэс 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Пүрэвийн Лхагвасүрэн 

Сэмжааны Батцэцэг 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Ирвэс, О., Лхагвасүрэн, П., Батцэцэг, С. (2025). Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн сургалтын орчинд нөлөөлж буй хувь нэмэр, зарим үр дүн. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 30(1). <https://doi.org/10.56380/mjer.v30.1.6>

The Contributions and Selected Outcomes Influencing the Educational Environment under Performance-Based Financing

Irves Ochir 

Mongolian State University of Education

Lkhagvasuren Purev 

Battsetseg Semjaan 

Mongolian State University of Education

To cite this article:

Irves, O., Lkhagvasuren, P., Battsetseg, S. (2025). The Contributions and Selected Outcomes Influencing the Educational Environment under Performance-Based Financing. *Mongolian Journal of Educational Research*, 30(1). <https://doi.org/10.56380/mjer.v30.1.6>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн сургалтын орчинд нөлөөлж буй хувь нэмэр, зарим үр дүн

Очирын Ирвэс, Пүрэвийн Лхагвасүрэн, Сэмжааны Батцэцэг

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2025.04.01

Засаж сайжруулсан: 2025.05.14

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2025.05.16

Түлхүүр үг:

Урамшуулалт төсөв гүйцэтгэлийн үнэлгээ

Хүүхдэд ээлтэй сургалтын орчин

Хүүхдийн хөгжил

ХУРААНГУЙ

Төрөөс боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт нь нийгэм, эдийн засгийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл гэх мэт олон бодлогыг хэрэгжүүлэх боломжтой. Сүүлийн жилүүдэд улс орнууд төдийгүй Монгол Улс ч боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байгаа нь боловсролын үр өгөөжийг эрхэмлэж буйн илрэл юм.

Энэхүү өгүүллээр бид цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2022, 2023 оны урамшууллын төсвийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын орчныг бүрдүүлэх сайн туршлагыг танилцуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхийг зорьж байна. Үр дүнд суурилсан төсөвлөлтийн гүйцэтгэлийн үр дүн, хүүхдийн хөгжлийг дэмжсэн сургалтын орчны өөрчлөлтийн талаарх мэдээллийг албан ёсны статистик болон кейс судалгаанд үндэслэсэн болно.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Сэмжааны Батцэцэг

Боловсрол судлалын сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Email: battsetseg.s@msue.edu.mn

The Contributions and Selected Outcomes Influencing the Educational Environment under Performance-Based Financing

Irves Ochir, Lkhagvasuren Purev, Battsetseg Semjaan

Article information

Article history:

Received: Apr 1, 2025

Revised: May 14, 2025

Accepted: May 16, 2025

Keywords:

ABSTRACT

Government investment in education can implement many policies such as human, social, economic development and labor market. In recent years, not only countries but also Mongolia have been increasing their investment in education, which is a sign that they value the benefits of education.

With this report, we aim to present, promote and spread the good practice of creating a learning environment to support children's development by analyzing the implementation of the 2022 and 2023 incentive budgets for kindergartens and secondary schools. Data on performance outcomes of results-based budgeting and changes in learning environments that support child development are based on official statistics and case studies.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Battsetseg Semjaan

Mongolian State University of Education

Email: battsetseg.s@msue.edu.mn

УДИРТГАЛ

Ерөнхий боловсролын санхүүжилт нь 30 гаруй жилийн өмнө зөвхөн улс, орон нутгийн төсвийн орлого, дотоодын хөрөнгө оруулалтаас түлхүүтэй бүрддэг байсан бол эдүгээ тэдгээрээс гадна гадаад улс орнууд, олон улсын санхүүгийн донор байгууллагуудын техникийн тусалцаа, буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээлийн төсөл, хөтөлбөрүүд, төрийн бус олон нийтийн байгууллагын болон уул уурхай, бизнесийн түншүүдийн хандив, дэмжлэгийн шинэ эх үүсвэрүүд бий болсон байна. Мөн түүнчлэн улсын, хувийн, олон улсын, хамтарсан зэрэг төрөл бүрийн өмчийн сургуулиуд, шавь сургалт, цахим нээлттэй сургууль, сургалтууд, мөн хувийн, гадаадын болон хамтарсан боловсролын үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын тоо нэмэгдсээр байна. Үүнтэй уялдан төр, засгаас боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалт, татвар, зээл, эдийн засгийн хэмнэлт, түүний урамшуулал, хариуцлагын ямар санхүүжилтын бодлого, стратеги, хууль эрх зүйн зохицуулалт хийх чиглэлээр боловсролын эдийн засгийн гүнзгийрүүлсэн бие даасан судалгаа, шинжилгээний ажил хийх хэрэгцээ, шаардлага улам бүр өсч байна. Өөрөөр хэлбэл, боловсролын санхүүжилт, түүний ашиглалтын өгөөж буюу сургалтын орчинд нөлөөлж буй байдал зэргийг тооцоолж, үнэлж, дүгнэх хэрэгцээ, шаардлага бий болсон.

Боловсролын санхүүжилтийн асуудал дан ганц төрөөс боловсролыг санхүүжүүлэх асуудлыг багтаадаггүй. Боловсролыг санхүүжүүлэхэд эцэг эх, өрх гэр, төрийн хийх үйлдлийг мөн судална. Харин боловсролын санхүүжилтийн талаарх хувь хүний үйлдэл нь хүмүүн капиталын онолоор тайлбарлагддаг.

Олон улсын хэмжээнд боловсролын бодлогыг хүний үндсэн эрх гэж авч үздэг учир боловсрол эзэмших эрхийг хүндэтгэх, биелүүлэх, хамгаалах нь төр, улсын үүргийн нэг болдог. Эдгээр үүргээс гадна хүний боловсрол эзэмших эрхийг батлан даагч болох ёстой (UNESCO, Rethinking Education. Towards a global common goods., 2015).

Монгол улсын Засгийн газрын газар энэхүү үүргээ тасралтгүй биелүүлж байгаа бөгөөд МУЗГ 2019 оны 5 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах тухай” 2022 оны А/368 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ийн дагуу зохион байгуулагдах “Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажил гүйцэтгэлийн үнэлгээ”-г 2022 онд улсын хэмжээнд анх зохион байгуулж үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн.

Мөн түүнчлэн гүйцэтгэлийн үнэлгээг цаашид жил бүр зохион байгуулах бөгөөд өөрийн өмнөх үр дүнгээ ахиулж чадсан багш нар дараа дараагийн жилд урамшуулалд хамрагдах боломж нээлттэй болсон төдийгүй “... багш бүр Албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ цаг тухай бүрт нь хэрхэн биелүүлж, төлөвлөлтийн дагуу хүүхдэд тухайн насандаа эзэмших чадваруудыг нь эзэмшүүлж, сургалт, үйл ажиллагааг тогтмол чанартай хийж гүйцэтгэж, үр дүнд хүрч байгааг нотлох түүний үр чадвар, мэргэшлийн бэлтгэл ямар байгааг баримт нотолгоонд нь үндэслэн дүгнэх...” үйл явц юм. Мөн сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог оновчтой бүрдүүлнэ хэмээн үзсэн юм.

Үр дүнд суурилсан санхүүжилтийн нэг чухал хэсэг нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн сургалтын орчин бүрдүүлэх үйл явц бөгөөд хүүхэд эрүүл, аюулгүй, таатай орчинд суралцаж хөгжих явдал юм. Энд:

- эрэлт, хэрэгцээнд нийцсэн сургалтын таатай орчныг бүрдүүлсэн байдал, ээлтэй сургалтын орчны үзүүлэлтийн хүртээмж, чанар, хүрсэн үр дүнг хэмжээсжүүлэх, өнөөгийн хүрсэн түвшин, өөрчлөлтийн зүй тогтлыг илрүүлэх зэргээр судалгаа, шинжилгээ хийх,
- хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн болон сэтгэл зүйн орчныг дэмжсэн сайн туршлагауудыг түгээн дэлгэрүүлэх, суралцахуйн ялгаатай байдлаас ангид байх үзүүлэлтүүдийг тооцдог, хянадаг, сайжруулдаг тогтолцоог бэхжүүлэх зэрэг хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Судалгааны зорилго: Улсын хэмжээнд урамшуулалт төсвийн 2022, 2023, 2024 оны гүйцэтгэлийг СӨББ болон ЕБС-аар гаргах, улмаар хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын орчин бүрдүүлсэн сайн туршлагыг танилцуулж, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх

Зорилтууд:

- 2022, 2023, 2024 оны урамшуулалт төсвийн гүйцэтгэлийг үндэслэн тархалтын цувааны шинжилгээг хийж хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын орчны бүрдүүлэлтийн өнөөгийн байдлыг тодруулах
- Ажлын байрны зураг авалт болон чанарын судалгаагаар сургалтын орчин бүрдүүлсэн СӨББ болон ЕБС-ийн сайн туршлага хуваалцах, урамшуулалт төсөвтэй хэрхэн хамааралтай болохыг тодруулах

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Энэ хэсэгт тухайн асуудал, сэдвийн талаар өмнө хийгдсэн судалгаанууд, тэдгээрийн үр дүнг тайлбарлан харуулав.

Тойм 1. Судлаачид санхүүжилтийн томьёо хэрэглэж буй улс орнуудын бодлогыг тэгш байдал (equity), хангалттай байдал (adequacy), үр ашиг (efficiency), ил тод, хариуцлагатай байдал (transparency and accountability), захиргааны зардал (administrative costs) гэсэн шалгуураар үнэлдэг (Заяадэлгэр, А., 2000, х45). Боловсролын сургалтын байгууллагын зардлын томьёонд үндэслэн санхүүжүүлэх буюу төсвийг суралцагчийн тоо гэх мэт хувьсагчийн математик томьёогоор тооцох аргачлалыг 1960 – аад оноос эхлэн хэрэглэж байв. 1990-ээд оноос АНУ, Австрали, Франц, Их Британи, Нидерланд, Шинэ Зеланд зэрэг улс санхүүжилтийн томьёог сургалтын бүх байгууллагадаа хэрэглэж эхэлжээ. Түүнээс хойш Финлянд, Унгар, Болгар, Молдав, Азербайжан, Армен, Монгол, Шриланк зэрэг олон оронд энэ аргачлал нэвтэрчээ (Fazekas, 2012). Улмаар энэхүү томьёогоор санхүүжүүлэх аргачлалыг тэгш байдал ба үр ашгийн стандартад нийцүүлж боловсронгуй болгох оролдлогуудыг улс орнууд туршиж нэвтрүүлсээр байна.

Бүх нийт боловсролын төлөө эвслийн “Монгол Улсын боловсролын төрийн санхүүжилт: Тэгш боломж, үр нөлөө (2006 он), Б.Отгонтөгсийн “Монгол Улсын боловсрол дахь тэгш бус байдал: хэмжигдэхүүн ба учир шалтгаан” (2019 он) зэрэг судалгааны бүтээлд зохих нотолгоо баримтад тулгуурлан шинжилсэн байна.

Сургуулийн эрэлт хэрэгцээ нь эдийн засаг, улс төр, нийгэм, соёлын хүчин зүйлсээс шалтгаалдаг. Эрэлтийн талын санхүүжилт нь хувь хүн болон түүний гэр бүлд төр, хувийн хэвшлийнхэнд зориулсан төрийн сангуудыг чиглүүлэх олон төрлийн арга хэмжээнүүд орно. Боловсрол шаарддаг хүмүүст биш харин нийлүүлэхийг шаарддаг хүмүүсийн гарт нөөцийг тавихад гол анхаарлаа хандуулна. (А.Мөнх-Оргил, 2018) Боловсролоор дамжуулан хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин, тогтвортой байдалд урт хугацаанд тогтвортой нөлөөлж чадна гэж үздэг нь боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлагын давуу тал юм. (Ч.Алтангэрэл, 2020)

Томьёонд үндэслэн санхүүжүүлэх аргачлал тухайн улсын хүн ам зүй, нийгэм – эдийн засгийн онцлогтой ихээхэн холбоотой байдаг. Иймээс АНУ зэрэг зарим улсад энэ аргачлал нэлээн маргаан дагуулдаг. Томьёонд үндэслэн санхүүжүүлэх арга нь ерөнхийдөө төвлөрлийг сааруулах хандлагатай холбоотой бөгөөд хуваарилсан төсвийг хэрхэн зарцуулахаа сургалтын байгууллага өөрсдөө шийддэг. Өөрөөр хэлбэл, томьёо ашиглах гол зорилго нь мөнгийг хэрхэн зарцуулах биш, харин хэрхэн хуваарилахад оршдог байна. Томьёонд ашиглаж буй гол хувьсагчид нь суралцагчийн тоо, бүлгийн түвшин (бага, дунд, ахлах, бэлтгэл), хэрэгцээ, хөтөлбөр, сургалтын байгууллагын шинж чанар, хүүхдийн нийгэм – эдийн засгийн шинж чанар зэргийг хамардаг бол гол коэффициент нь тухайн хувьсагчийг үржүүлэх мөнгөн дүн байдаг. Гэхдээ эдгээр нь боловсролын салбарын бодлогын зорилготой уялдаж өөр өөр үүрэгтэй байна.

Тойм 2: Академич Н.Бэгз, доктор Г.Өлзийсайхан нарын үзсэнээр боловсролын эдийн засгийн судалгаа, мэргэшсэн судлаач харьцангуй цөөн байна. Манай орны эрдэмтэн судлаач, эдийн засагчид боловсролын эдийн засаг, санхүүжилтийн асуудлаар судалгаа, шинжилгээний ажлыг тодорхой чиглэлээр хийж гадаад, дотоодод эрдмийн зэрэг, цолыг хамгаалсан байна. Тухайлбал, академич Б.Энхтүвшин /1982/, доктор Б.Бэхтөр /1981/, профессор С.Ламбаа /1987/, профессор Р.Бандий /1991/, доктор Л.Болдбаатар /2003/, доктор Б.Буянзаяа /2015/, доктор Д.Батчулуун /2016/ нар дээд, тусгай дунд боловсролын эдийн засаг, санхүүжилт, төлөвлөлт, статистикийн чиглэлээр, харин профессор Н.Наранчимэг /2002/, доктор Ч.Буянжаргал /2003/ боловсролын хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн асуудлыг, доктор Ж.Цэвээндорж /2006/ боловсролыг санхүүгийн удирдлагаар дэмжих, доктор Т.Батболд /2014/ боловсролын хөрөнгө оруулалтын өгөөжийн шинжилгээний асуудал, доктор А.Мөнх-Оргил/2.../, доктор О.Хуягцогт/2000/, доктор С.Батцэцэг /2021/ ерөнхий боловсролын санхүүжилтийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг хөндсөн судалгааны ажил хийж эрдмийн зэргийг хамгаалжээ. Мөн түүнчлэн Монгол улсын боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлыг тусгасан Н.Бэгз /2011/, Б.Жадамба /2002/, Ч.Пүрэвдорж /1999/ эрдмийн ажлууд байна.

Мөн доктор Г.Өлзийсайхан боловсролын санхүүжилтийн тэгш байдал, доктор Д.Ариунаа боловсролын эдийн засаг, А.Заяадэлгэр боловсролын макро, мезо, микро эдийн засгийн зарим асуудлыг тусгасан сурах бичиг, гарын авлага гаргасан байна.

Тойм 3. Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ноогдох зардлын тэгш байдал аймаг, хотын хооронд ямар түвшинд байгааг судалж улмаар санхүүжилтийн тэгш байдал сайжирч байгааг тодруулав (Өлзийсайхан, Г 2013). Засгийн газар, орон нутгийн удирдах байгууллагын гол үйл ажиллагаа нь төсөв бүрдүүлэх, бүрдсэн төсвийг зүй зохистой хуваарилах явдал юм. Боловсролын санхүүжилтийн зорилго нь боловсрол эзэмших эрхийг зүй зохистой хуваарилах, өөрөөр хэлбэл, боловсролын үйлчилгээг тасралтгүй

явуулахад тусалдаг тул хуваарилалтаддээрх 2 чиглэлийг нэгтгэн судлах хандлага давамгайл байна (Kong, Chun, 1989:33). Тэрээр санхүүжих нэг сурагчид ногдох нийт урсгал зардал, цалингийн зардал, бусад урсгал зардал тэгш байдлыг хангаж чадаагүй, гэхдээ жил ирэх тутам эдгээр үзүүлэлт сайжирч байгаа гэв. 2007 болон 2011 оны санхүүгийн тайланг ашиглан ЕБС-ийн нэг сурагчид ногдох норматив зардлын өөрчлөлт нь тэгш байдалд хэрхэн нөлөөлж байгааг санхүүжилтийн хэвтээ, босоо тэгш байдлыг хангаж буйг индекс тооцож харьцуулах замаар тодруулсан байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)-д Монгол Улсын хувьд нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжсэнээс хойш сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын цөөнгүй хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн боловч тэдгээрийг нэгдсэн үзэл баримтлалын хүрээнд боловсруулж, хэрэгжилтийг тогтвортой хангах санхүү, төсөв болон багшийн хөгжлийн урьдач нөхцөлийг хангалттай бэлтгэж чаддаггүй байсан нь сорилт, бэрхшээл болж ирсэн гэжээ.

Тойм 4. Ерөнхий боловсролын санхүүжилтийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг макро үзүүлэлтээр тооцож, холбоо хамаарлыг тооцсон байдаг. (Батцэцэг, С., 2021). Боловсрол, сургалтад оруулах хөрөнгө оруулалт, түүний үр өгөөжийг судлах нь хүмүүн капиталын онолын судалгааны гол хэсэг юм (Jacob Mincer, 1957). Хүн сургуульд суралцахдаа ирээдүйд сайн сайхан ажил хийж, сайхан амьдарна гэж итгэдэг. Хувь хүний хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцохдоо боловсролд зарцуулсан нийт хөрөнгө оруулалтыг тухайн хүний боловсрол эзэмшсэнээрээ олох нэмэлт орлоготой, харин нийгмийн өгөөжийг тооцохдоо тухайн нийгмийн боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалтыг түүнээс хүртэж болох эдийн засгийн үр ашигтай харьцуулдаг. Түүнчлэн эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх боловсролын нөлөөлөл дээр нийгмийн өгөөжийг мөнгөөр хэмжээжүүлж оруулахыг хичээдэг (Gary Becker, 1964). Үүнтэй уялдан төр, засгаас боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалт, татвар, зээл, эдийн засгийн хэмнэлт, түүний урамшуулал, хариуцлагын ямар санхүүжилтын бодлого, стратеги, хууль эрх зүйн зохицуулалт хийх чиглэлээр боловсролын эдийн засгийн гүнзгийрүүлсэн бие даасан судалгаа, шинжилгээний ажил хийх хэрэгцээ, шаардлага улам бүр өсч байна. Өөрөөр хэлбэл, боловсролын төсөв, санхүүжилт, түүний ашиглалтын өгөөж, үр ашгийг тооцоолж, үнэлж, дүгнэдэг уламжлалт арга, хэлбэрийг өөрчилж, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий болсон гэв. 2000-2020 он хугацааны цувааг макро үзүүлэлтээр байгуулж ерөнхий боловсролын санхүүжилт болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн хамаарлыг хугацааны хоцрогдолтойгоор тооцжээ.

АРГА ЗҮЙ

Боловсролын эдийн засаг гэх эдийн засгийн дэд салбар нь анх 1960 оны 12 сард АНУ-ын эдийн засгийн холбоонд Теодер Шкалц (Theodore Schultz) “Боловсрол бол хүмүүн капиталд оруулж буй хөрөнгө оруулалт мөн” гэж хэлсэн цагаас үүсч, улмаар анхдагч АНУ төдийгүй Дэлхийн банк, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагууд энэ чиглэлээр судалгааны ажил хийгээд 60 гаруй жил болж байна.

Боловсролын эдийн засаг нь боловсролын үйлдвэрлэл, хувь хүн, нийгмийн бүлгүүдийн дунд боловсролыг тэгш хүртээх асуудал, боловсролд нийгмийн зүгээс болон хувь хүн зарцуулах нөөцийн хуваарилалт санхүүжүүлэх шалгуур хэлбэрийг сонгох асуудлыг багтаадаг [Lachana G, Hussein J. Economics of Education Discovery pub. House, India, 2007]. Иймд улс орны эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд боловсролын үүрэг өндрөөр үнэлэгдэж, татвар төлөгчдөөс цуглуулсан хөрөнгийн ихээхэн хэсгийг төр боловсролын үйлчилгээнд зарцуулдаг байна. Боловсролд багагүй хэмжээний хөрөнгө зарцуулж буй учраас энэхүү хөрөнгөөр хийж бүтээхээр зорисон зорилтоо биелүүлж чадаж байгаа эсэх нь чухал юм. Тухайн улс орны хөгжлийн бодлоготой холбоотойгоор дэвшүүлэх боловсролын зорилтыг хэрэгжүүлэхэд боловсролын санхүүжилтийн бодлого чиглэнэ.

Өнөөг хүртэл тэгш боломж бий болгох, тэгш байдлыг хангах чиглэлээр боловсролыг санхүүжүүлж ирсэн нь бэрхшээлтэй тулгарсаар байна. Сүүлийн жилүүдэд боловсролын санхүүжилтийн хүрсэн үр дүнгийн талаарх асуудал хөндөгдөж (Jinsub Choi. 2023), сургалтын таатай орчин, түүний тэгш байдлыг хангахаар зарцуулж буй хөрөнгө хотын төвөөс алслагдсан, суралцагчийн тоо бага сургалтын байгууллагад хүрч үйлчлэхгүй, сургалтын орчны стандарт, хүүхдэд ээлтэй байдал зэргийг тодорхойлж тайлагнах, хянах зэргээр ялгаатай байна хэмээн таамаглаж байна.

Судалгаанд боловсролын яам, үнэлгээний төвөөс гаргасан 2022-2024 оны бусад хувьсах зардлын мэдээллийг ашигласан болно.

Мэдээллийн дүн шинжилгээ. Судалгааг хүлээгдэж буй үр дүнгээс хамааруулан тоон болон чанарын аргуудыг хослуулан хэрэглсэн бөгөөд мэдээллийг SPSS22, MS EXCEL программд кодлолын дагуу шивж оруулан механик болон логик алдааг шалгаж чанарын шаардлагад нийцүүлсний дараа мэдээллийн боловсруулалт, шинжилгээг хийсэн. Тоо хувиар илэрхийлэгдэх дан тоололтын зэрэгцээ шинж тэмдгээр

ангилах, статистик үзүүлэлт (дундаж, голч, түгээмэл утга, хамгийн их, бага утга, стандарт хазайлт)-ийг тооцох, бүлэглэх зэргээр харьцуулан шинжилсэн. Таамаглал шалгах шинжилгээг хийхдээ аймгийн төвийн болон нийслэлийн сургуулийг нэг бүлэг, сум орон нутгийн сургуулийг тусд нь нэг бүлэг болгон ялгаатай түүврүүдийн дундаж утга (Independent Samples Test) тэнцүү, ялгаатай гэсэн альтернатив таамаглал дэвшүүлэн шалгасан болно. Мөн ажлын байрны зураг авалт болон ганцаарчилсан ярилцлагын аргаар авсан мэдээллийг ангилан боловсруулав.

ҮР ДҮН

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлсэн.

Энэхүү төсвийн шинэчлэлийн хүрээнд

- Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал
- Хичээл практикийн зардал
- Мэдээлэл технологийн зардал
- Багшийн хөгжлийг дэмжих зардал
- Эрүүл мэндийг дэмжих зардлыг тус тус олгодог болов.


Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг “Хүүхдэд ээлтэй сургалтын орчин зориулалтын (81816)”, “Бараа үйлчилгээний бусад зардал /багаж хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж/ (210901)” гэсэн эдийн засгийн ангилалд төлөвлөн хуваарилж санхүүжүүлэх бөгөөд өөрчлөлтийн зүй тогтлыг хүснэгт 1-ээр харуулав.

Хүснэгт 1. Нөхөн хангалтын болон хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардлын санхүүжилт

	Зориулалт	ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоол	ЗГ-ын 2024 оны 39 дүгээр тогтоол	ЗГ-ын 2024 оны 53 дугаар тогтоол
1.	Ерөнхий боловсролын сургууль	Нийт хувьсах зардлын 4-15 хувь	Нийт хувьсах зардлын 3.2-14 хувь хүртэл	
2.	Цэцэрлэг	Нийт хувьсах зардлын 0.5 хувь	Нийт хувьсах зардлын 0.4 хувь	Нийт хувьсах зардлын Нийслэл- 0.353 хувь, Аймаг 0.322 хувь, Сум 0.282 хувь

ҮР ДҮН 1. Урамшуулалт төсөв авах сургалтын байгууллагын тоо өсөх хандлага байна. Цаашид хүүхдэд ээлтэй сургалтын орчны бүрдүүлэлтэд анхаарах нь зүйтэй. Тодруулбал, боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1635 сургалтын байгууллагад 43606.7 сая төгрөгийн нөхөн хангалтын буюу хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх зориулалт бүхий зардал хуваарилагдсан байна.


Зураг 1. Нөхөн хангалтын буюу хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх зориулалт бүхий төсвийн зардал, сая төгрөгөөр



Эх сурвалж: БШУЯ, 2024

ЕБС-ийн хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх зардал нь жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай бөгөөд нэг ЕБС-д дунджаар 50 гаруй сая төгрөг ногдож байна.


Зураг 2. ЕБС-ийн нөхөн хангалтын буюу хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардал, сая төгрөг



Эх сурвалж: БШУЯ, 2024

Харин СӨББ-ын хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх зардал нь жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай бөгөөд нэг цэцэрлэгт 4 сая төгрөг ногдож байна.


Зураг 2. ЕБС-ийн нөхөн хангалтын буюу хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардал, сая төгрөг



Эх сурвалж: БШУЯ, 2024

Өнөөгийн байдлаар цэцэрлэг (СӨББ) болон ЕБС-ийн 60 орчим хувь нь V түвшинд үнэлэгдэж 40 гаруй хувь нь 2-8 хувийн урамшуулалт төсөв авч (Зураг 2-оос харна уу) цаашид урамшуулалт төсөв авах сургалтын байгууллагын тоо өсөх хандлага байна.

Зураг 2. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, индексийн түвшнээр, хувиар




Эх сурвалж: БШУЯ, 2024

2024 оны байдлаар тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг “Хүүхдэд ээлтэй сургалтын орчин зориулалтын (81816)”, “Бараа үйлчилгээний бусад зардал /багаж хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж/ (210901)” гэсэн эдийн засгийн ангилалд төлөвлөн хуваарилж санхүүжүүлсэн байдлыг ЕБС-иар авч үзлээ.

Энд аймгийн төв болон нийслэлийн сургуулийг нэг бүлэг, сум орон нутгийн сургуулийг тусд нь нэг бүлэг болгон ялгаатай байдлын шинжилгээг хийж үзэхэд:

Зураг 3. Нөхөн хангалтын зардлын тархалт, 2024 гүйцэтгэл, ЕБС-аар



Хүснэгт 2. Нөхөн хангалтын зардлын статистик үзүүлэлт, 2024 гүйцэтгэл, ЕБС-аар

Statistics		
HX3 гүйцэтгэл		
N	Valid	668
	Missing	18
Mean		53715.694
Median		39533.100
Mode		14700.0
Std. Deviation		42051.3519
Skewness		1.629
Std. Error of Skewness		.095
Kurtosis		3.001
Std. Error of Kurtosis		.189
Minimum		1800.0
Maximum		241569.4
Percentiles	25	23884.250
	50	39533.100
	75	72865.250

2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 668 сургууль нөхөн хангалтын зардлыг авсан бол 18 сургууль ямар нэг шалтгаанаар аваагүй.

Энд хамгийн ихдээ 241,569.4 сая төгрөг, хамгийн багадаа 1,800.0 сая төгрөг, дунджаар нэг сургуульд 53,715.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Нийт сургуулийн 50-аас дээш хувь нь 39,533.1 сая төгрөгөөс доош, дундаж утгаас хазайх хазайлт нь 42,051.3 сая төгрөг, дийлэнх сургууль нь 14,700.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна (*Хүснэгт-2*).

Энд ассиметрийн коэффициент 1.629 (*Skewness*>0) байгаа нь дундаж санхүүжилтын утгаас бага утга олон байгааг, эксцессийн коэффициент 3.001 (*Kurtosis*>0) байгаа нь дундаж утгаас сарнисан байгааг тус тус харуулж байна (*Зураг-3*).

Хүснэгт 2, Зураг 3-аас харахад энэхүү санхүүжилт нилээд ялгаатай байгаа нь харагдаж байна. Энэхүү ялгаатай байдлыг дэлгэрүүлэн нийслэл, орон нутгийн сургууль буюу байршлын үзүүлэлтээр ялгаатай байгааг тодруулан таамаглал шалгах шинжилгээг хийж үзье.

Хүснэгт 3. Таамаглал шалгах шинжилгээний үр дүн, нөхөн хангалтын зардал, 2024 гүйцэтгэл, ЕБС-аар

Group Statistics										
	Ангилал		N		Mean		Std. Deviation		Std. Error Mean	
HX3 /гүйцэтгэл/	Аймгийн төв, нийслэл		279		82918.65		47777.7586		2860.3796	
	Сумын төв		389		32770.63		18741.6640		950.2401	
Independent Samples Test										
	Levene's Test for Equality of Variances		t-test for Equality of Means							
	F	Sig.	t	df	Sig. (2- tailed)	Mean Difference	Std. Error Difference	95% Confidence Interval of the Difference		
								Lower	Upper	

HX3	Equal variances assumed	185.15	.000	18.78	666	.000	50148.02	2669.11	44907.1	55388.9
	Equal variances not assumed			16.63	339.78	.000	50148.02	3014.08	44219.3	56076.6

Энд нөхөн хангалтын зардал байршлаас хамааран ялгаатай гэсэн өрсөлдөгч таамаглал статистикийн ач холбогдолтойгоор ($t, df, Sig.(2-tailed) \leq 0.005$) дэмжигдэж байна. Өөрөөр хэлбэл, сум орон нутгийн сургуулийн зардал, нийслэл, аймгийн төвийн сургуулийн нөхөн хангалтын зардал зардлаас 50,148.02 сая төгрөгөөр бага байна. 95%-ийн магадлалтайгаар үр дүн хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд өөрчлөлтийн итгэх завсар нь (44,219.3-56,076.6 сая төг) байна (*Хүснэгт 3-аас харна уу*). Энэ нь суралцагчийн тоо болон бусад үзүүлэлтээс хамаарч байгаа хэдий ч сургалтын ялгаатай орныг дэмжсэн үзүүлэлт болох талтай учир цаашид энэ санхүүжилтийн гүйцэтгэлд анхаарах нь зүйтэй.

ҮР ДҮН 2. Мөн сургуулийн санхүүгийн эрх мэдэлд тулгуурлан урамшуулалт төсвийн санхүүжилтийг сургууль цэцэрлэгүүд авч эхэлсэн. Үүний хүрсэн үр дүн болох хүүхдийн хөгжлийг дэмжсэн сургалтын орчин бүрдүүлэх үйл явц, сургалтын орчныг бүрдүүлсэн сайн туршлагыг хуваалцах хэрэгтэй. Энд:

А. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 7-р цэцэрлэг



Говь цөл нутгийн өнгөрсөн, одоо, ирээдүй цагийг харуулсан 3D орчин



Ном угших арга зүй, номын фондоо төрөлжүүлсэн усан онгоц бүхий хичээлийн хэрэглэгдэхүүн

Б. Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2-р сургууль



*Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн түүхий эдийн дээж бүхий
байгалын ухааны хичээлийн хэрэглэгдэхүүн -Сургалтын орчин*

Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийг дэмжсэн сургалтын таатай орчин (материаллаг, сэтгэл зүйн г.м)-ыг бүрдүүлэхэд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, харилцан туршлагаа хуваалцах, боломж, нөөцөө солилцох зэргээр бүтээлч байдлыг дэмжин цаашид хэрхэн ашиглагдаж байгааг удирдах тогтолцоо хэрэгтэй байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгааны үр дүнг өмнө нь 2022, 2023 оноор хийж “Боловсролын шинэ эрин-2024” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлж байсан бөгөөд илтгэл нь танин мэдэхүйн, мэдээллийн ач холбогдолтой гэж хэлж болохоор байсан. Учир нь ЕБС-ийн үр дүнд суурилсан санхүүжилт (тэр дундаа нөхөн хангалтын зардал), урамшуулалт төсвийн талаарх ойлголт харьцангуй сул байгаа нь ажиглагдсан. Энэ нь багш нарын оролцоо дутмаг байгаагийн илрэл гэж үзэж байна. Нөгөө талаар санхүүжилтийн бүтэц, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, ашиглалт, сайжруулалт бүхий цогц үйл ажиллагаа, түүнийг удирдан зохион байгуулах хүний нөөц, тэдгээрийн мэдлэг, хандлага дутмаг байгаагийн илрэл юм. Иймд:

- Бидний тодорхойлсон үр дүнгүүд төсвийн зардлын бүтэц, төсөв санхүүгийн ил тод байдал, оролцогч талуудын оролцоо зэргээр өргөжин тэлж байна.
- Энэ судалгаа нь үр дүнд суурилсан санхүүжилтийг олгох үндэслэл бүхий оношилгоо, үр дүн бүхий динамикийн талаар шинэ ойлголтыг санал болгох бөгөөд өгөгдөл цуглуулах, өгөгдөл, үр дүнгийн найдвартай байдалд анхаарч байна.
- Бидний хийсэн үр дүн бүхий санхүүжилтийн өгөгдлөөр хийсэн харьцуулах, таамаглал шалгах шинжилгээ нь хүүхдэд ээлтэй орчны бүрдүүлэлтэд чиглэсэн буюу зорилгодоо хэрхэн хүрсэн талаарх (урьд өмнө судлагдаагүй) нарийн төвөгтэй харилцааг тодруулсан.
- Эдгээр үр дүнг харгалзан үзээд нөхөн хангалтын зардлын зарцуулалтад (ялгаатай байдал, үр ашгийг дээшлүүлэх, бусад зардалд шилжүүлэн зарцуулж буй зөрчлийг хянах г.м) хандах хандлагыг эргэн харах нь чухал юм.

ДҮГНЭЛТ

Улс орон бүрийн өөрийн өвөрмөц, дахин давтагдашгүй чанарыг агуулсан газар нутаг, хүн ам, түүх, соёл, ёс заншилтай бөгөөд эдгээртэй уялдсан төрийн байгуулалт, эдийн засаг, нийгмийн бүтэцтэй. Улсын төдийгүй боловсролын хөгжлийн бодлогоо төлөвлөхдөө ч өөрийн орны онцлог шинжид тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлдэг. Энэхүү ялгаатай байдлыг харгалзан үзэлгүйгээр улс орнуудын хөгжлийн бодлого төлөвлөх механизмыг шууд харьцуулан авч үзэх нь учир дутагдалтай юм. Иймд судалгааны боловсруулалт, үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Үр дүнд суурилсан санхүүжилт нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн сургалтын орчин бүрдүүлэх үйл явцад тодорхой хувь нэмэр оруулжээ.
- Урамшуулалт төсвийн хуваарилалтыг захиран зарцуулахад удирдлагаас гадна багш, эцэг эхийн оролцоог үндэслэн сургалтын орчныг сайжруулах ажлууд хийгдэж байгаа нь хүүхэд, гэр бүл, олон нийттэй ажиллах хамтын ажиллагаанд ахиц гарах боломж байгааг харуулж байна.
- Төсвийн бодлого, эрхзүйн баримт бичгүүдийг сургалтын байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх байдал нь өссөн байна. Энэ нь оролцогч талуудын бодлогын баримт бичгийг практикт хэрэгжүүлэх зааварчилгаа тодорхой, хамтын ажиллагаа сайн байсантай холбоотой байна.

Цаашид байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг дагасан урамшуулалт төсвийн хуваарилалтад анхаарах дараах шаардлагууд байна.

- Үр дүнд суурилсан санхүүжилтийг олох үндэслэл бүхий оношилгоо, үр дүнг үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулах орчин нөхцөл, тогтолцоог сайжруулах
- Зардлын зарцуулалтын ялгаатай байдал, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарах
- Сургалтын орчны стандарт, хүүхдэд ээлтэй байдал зэргийг тодорхойлж тайлагнах, бусад зардалд шилжүүлэн зарцуулж буй зөрчлийг хянах,
- Хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын таатай орчныг бүрдүүлэхэд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх
- Бүтээлч ажлын хэрэглээ, ашиглалтын үзүүлэлтийг тооцох зэргээр сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

ТАЛАРХАЛ

Энэхүү өгүүллийг бичихэд дараах бодлогын баримт бичгүүд тус болсон бөгөөд мэргэжлийн зөвлөгөө өгч тусалсан хүмүүст талархаж байна. Энд:

- Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЮНЕСКО, ЮНИСЕФ зэрэг олон улсын санхүүжүүлэгч донор байгууллагуудын дэмжлэгтэй боловсруулсан “Боловсролын салбарын 1995-2000, 2001-2005, 2006-2015 Мастер Төлөвлөгөө”, “Боловсролын Бодлогын Тойм судалгаа” БХ, ЮНЕСКО болон ТББ, ИНБ-ууд төрөлжсөн хөгжлийн хөтөлбөрт зориулсан салбар, дэд салбарын судалгааны төслүүдээр боловсролын санхүүжилт, төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын байдалд судалгаа, задлан шинжилгээ хийсэн дүгнэлт, хөгжлийн тодорхой санал, зөвлөмжүүд
- АХБ-ны дэмжлэгтэйгээр 1995 онд олон улсын зөвлөх доктор И.Мемнаф, дотоодын зөвлөх Ж.Сүхбаатар, А.Батжаргал, Р.Бандий зэрэг үндэсний эрдэмтэн судлаачдын баг хамтран Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудын байршил, бүтэц, хэв, шинж, багш, багш бус ажилтны орон тоо, тэдний тооны харьцаа, бүрэлдэхүүн, чанар, эдийн засгийн үр ашгийн талаарх цогц судалгаа шинжилгээний ажлын дүгнэлт, зөвлөмжүүд

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: О.И., С.Б; **Арга зүй:** О.И., П.Л; **Мэдээлэл цуглуулалт:** О.И., С.Б; **Бичилт (эхний хувилбар):** О.И., С.Б., П.Л; **Бичилт (засвар):** О.И., П.Л., С.Б; **Санхүүжилт:** О.И; **Нөөц:** П.Л; **Мэргэжлийн удирдлага:** С.Б.

НОМ ЗҮЙ**Өгүүлэл**

Ulziisaikhan. G., (2013). *An Equity Analysis of Mongolian Elementary and Secondary school Educational Finance*. Journal of Education for International understanding, 8(1), 25-26. In Mincer, Jacob; Polachek, Solomon (March–April 1974). *"Family investments in human capital: earnings of women"*, *Journal of Political Economy*. 82 (2): s76 – s108. doi:10.1086/260293. JSTOR 1829993. S2CID 154095476.

Meshaal J. Alshammmary. (2014). *Financial Development and Economic Growth in Developing Countries: Evidence from Saudi Arabia*, ISSN 1727-9232

Jinsub Choi. (2023). *School finance centralization and revenue levels: evidence from a school finance reform*, Journal of Applied Economics, 26:1, 2283339, DOI: 10.1080/15140326.2023.2283339

Ном

Бэгз, Н. (2008). *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд*. Соёмбо принтинг. Боловсролын хүрээлэн. (2018). *Боловсролын хөгжил: Судалгаа, арга зүй*. Гоо дизайн.

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам [БШУЯ]. (2020-2023). Цэцэрлэг болон ЕБС-ийн төсвийн төлөвлөлтийн тоон мэдээлэл: Улаанбаатар, Монгол Улс.

Заяадэлгэр, А. (2011). Боловсролын эдийн засаг. Мөнхийн үсэг.

Department of Education of England, *Schools block national funding formula: technical note*. (2021).

Gary S. Becker. (January 1964). *Human Capital: A Theoretical and Empirical Analysis with Special Reference to Education, First Edition*. National Bureau of economic Research

Эрдэм шинжилгээний хурлын илтгэл

Ikhlas Fuad Zamzami & Murni Mahmud (23-24 November 2011). *Proposing a framework for evaluating information quality of mobile interface design for electronic government services*

DOI: [10.1109/ICRIIS.2011.6125734](https://doi.org/10.1109/ICRIIS.2011.6125734). International Conference on Research and Innovation in Information Systems, Kuala Lumpur, Malaysia

Заяадэлгэр, А., & С.Эрдэнэчимэг. (2020) *Боловсролын салбарын төсвийн зарлагын хандлагын шинжилгээ*. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. Улаанбаатар, Монгол Улс.

Батцэцэг, С., Ирвэс, О., Лхагвасүрэн, П., (2024). “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн сургалтын орчинд нөлөөлж буй хувь нэмэр, зарим үр дүн”. Боловсролын шинэ эрин -2024 Олон улсын эрдэм шинжилгээний хурал, Монгол улс, Архангай аймаг

Хууль, бодлогын баримт бичиг

Боловсролын ерөнхий хууль 2023. (Монгол Улс). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. 2023. (Монгол Улс).

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959012931>

Монгол Улсын Засгийн газрын тогтоол. (2022). Дугаар 91 тогтоол. Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468212335341>

Монгол Улсын Засгийн газрын тогтоол. (2024). Дугаар 39 тогтоол. Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089357508301>

Монгол Улсын Засгийн газрын тогтоол. (2024). Дугаар 53. Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141293183621>

UNESCO (2015), *Rethinking Education. Towards a global common goods.*, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000232555>

Нийслэлийн Боловсролын Газар [НБГ]. (2023-2024). Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн төлөвлөгөөний тоон мэдээлэл: Улаанбаатар, Монгол Улс.

Education Working Papers No.74 <https://files.eric.ed.gov/fulltext/ED532029.pdf>. (2012).

Үндэсний статистикийн хороо [ҮСХ]. (2024). Нэгдсэн мэдээллийн сан. <http://www.1212.mn/>

Диссертаци

Zagir, T. (2021). *Professional identity and competences of adult learning facilitators: Perspectives from Mongolian non-formal adult education* (Doctoral dissertation). Eötvös Loránd University, Hungary. DOI: 10.15476/ELTE.2021.135

Мөнх-Оргил, А. (2018). Монгол улсын боловсролын салбарын төсвийн санхүүжилтийн судалгаа.

<https://e-lib.cis.mn/reader/8273?page=0>

Алтангэрэл, Ч. (2020). Ерөнхий боловсролын бодлогыг хүний эрхэд суурилсан хандлагаар шинжилсэн нь.

<https://e-lib.cis.mn/reader/8092?page=0>

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Очир Ирвэс

 <https://orcid.org/0000-0001-6986-1448>

Байгууллагын нэр: Монгол Улсын Боловсролын Их Сургууль, докторант

Хаяг: Улаанбаатар хот, СБД, VIII хороо, Бага тойруу-14, Улаанбаатар-48, Монгол улс-14191

Улс: Монгол

e-mail: irves@mnier.mn

Овог, нэр: Пүрэв Лхагвасүрэн



Байгууллагын нэр:

Хаяг: Улаанбаатар хот, СБД, VIII хороо, Бага тойруу-14, Улаанбаатар-48, Монгол улс-14191

Улс: Монгол

e-mail: p_lkhagva@yahoo.com

Овог, нэр: Сэмжаан Батцэцэг

 <https://orcid.org/0009-0001-3768-6355>

Байгууллагын нэр: Монгол Улсын Боловсролын Их Сургууль, ахлах багш

Хаяг: Улаанбаатар хот, СБД, VIII хороо, Бага тойруу-14, Улаанбаатар-48, Монгол улс-14191

Улс: Монгол

e-mail: battsetseg.s@msue.edu.mn